

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦАА : XX ЗУУНЫ СҮҮЛИЙН 10 ЖИЛД

*ШУА-ийн ОУСХ-ийн ЭША,
доктор Ц.Баатар*

XX зууны сүүлийн 10 жилийн Монгол улс хараат эдийн засагтай, буурай хөгжилтэй орон хэвээр байсан хэдий ч зах зээлийн эдийн засгийг баримжаалсан, нээлттэй гадаад бодлого баримталж гадаад эдийн засаг, худалдааны хувьд хуучин түншүүдийн зэрэгцээ шинэ шинэ түнштэй болж эдийн засгийн гадаад харилцаа урьд өмнөхтэй харьцуулахын аргагүй өргөжсөн түүхэн зурвас үе байлаа. Гадаад худалдаа, эдийн засаг ийнхүү өргөн цар хүрээтэйгээр өргөжин тэлэхийн зэрэгцээ Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Худалдааны Байгууллага зэрэг олон улсын банк, санхүү, худалдааны байгууллагатай нягт хамтран ажилладаг, дэлхийн олон оронтой худалдаа, эдийн засгийн үр ашигтай өргөн харилцаатай орон боллоо.

Монгол улсын хувьд гадаад худалдаа эрхэлж эхэлсэн түүх бусад улс орны нэгэн адил нэн эртний баялаг уламжлалтай билээ. Тэр бүхнийг энд өгүүлэх боломжгүй тул зөвхөн сүүлийн 10 жилийн гадаад худалдаа, эдийн засгийн талаар өөрийн санал бодлоо дараахи хэдэн зүйлээр цухас өгүүлэхийг хичээе.

Нэг. Эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаанд гарсан өөрчлөлт

Монголын төр засаг 1990-ээд оноос эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааг чөлөөтэй болгох бодлого тууштай баримталж, олон талт харилцааг өргөтгөх, арга хэлбэрийг нь боловсронгуй болгох чиглэлээр ихээхэн хүчин чармайлт тавьж ирлээ. Тухайлбал, 1994 онд батлагдсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд "... тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр тус улсын эдийн засгийн хэтийн болон цаг үеийн зорилтыг зохистой шийдвэрлэхэд гадаад хүчин зүйлийг зохистой ашиглах, улмаар улс орны эдийн засгийг бүс нутгийн интеграцид өөрийн гэсэн байр суурьтай болгоход оршино" гэж тодорхойлжээ. Уг үзэл баримтлалд Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үндсэн салбаруудыг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний олон улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зэрэг үндсэн 10 чиглэлийг баримтлахаар тусгасан байдаг. Өнгөрсөн богино хугацаанд төр засаг энэхүү үзэл баримтлалыг гадаад эдийн засгийн бодлогодоо тууштай баримталж хөрш зэргэлдээ улс орон болон Европ, Америк, Азийн улс орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөн гүнзгийрүүлэх, олон улсын байгууллагууд, тухайлбал, Олон Улсын

Валютын Сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг санхүү эдийн засгийн байгууллагуудтай бүх талаар хамтран ажиллах чиглэлийг тууштай барьж ажилласан явдал шилжилтийн хүндрэл бэрхшээлийг гарз хохирол багатай даван туулах, эдийн засгийн суурь үндсийг эрүүлжүүлэх, цаашдын хөгжлийн зөв эхлэлийг тавихад чухал хүчин зүйл болсон юм. 1991 онд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, 1994 онд Азийн Хөгжлийн Банк, 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага Монгол улсын хүсэлтийг анхааран үзэж гишүүнээрээ элсүүлэн авсан явдал нь олон улсын тавцанд Монгол Улсын ардчиллын үйл явцыг дэмжиж, нэр хүндийг нь дээшлүүлэх, эдийн засаг, санхүүгийн глобалчлалын гадна үлдээхгүйг хичээсэн ихээхэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон билээ. Монголын ардчилсан төр энэхүү гадаад таатай орчин нөхцлийг бүтээлчээр ашиглах үүднээс дэлхийн санхүү-банкны тусламж дэмжлэгтэйгээр банк-санхүүгийн шинэтгэлийг хэдий удаашралтай ч гэсэн олон улсын жишигт нийцүүлэн хийж эхэллээ. Монгол улс дээрх байгууллагуудын гишүүнд элссэнээр эдийн засгийн гол гол амин чухал гэсэн салбар, хэсэгт гадаадын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авах боломж нөхцлийг бүрдүүллээ.

Хоёр. Хөрөнгө оруулалт, зээл, тусламж

Азид анхны ардчилсан төр засгаа төвхнүүлж буй Монгол улсыг дэмжих үүргийг Япон улс Их наймын өмнө хүлээж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага, улс орнуудын анхаарлыг Монгол руу чиглүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт тавьж, чухал ач холбогдолтой, үр дүнтэй олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсээр байна. Үүний нэг тодорхой илрэл нь Японы засгийн газрын санаачлагаар 1991 оноос 2001 он буюу сүүлийн арван жилд найман удаа /Токиод 6 удаа, Улаанбаатарт 1, Парист 1 удаа/ зохион байгуулагдсан юм. Энэ хугацаанд манай орны өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжигч хандивлагч орнууд ба олон улсын байгууллагын хүрээ өргөжиж, одоо 30 орчим орон, олон улсын 14 байгууллага түүнд нэгдэн ороод байна.

2001 оны 5-р сард Парис хотноо болсон 8 дахь удаагийн "Зөвлөлдөх уулзалт"-нд 18 орон ба олон улсын 14 байгууллагын төлөөлөгчид оролцжээ.

1991 оноос 2000 он хүртэл хандивлагч орнууд ба олон улсын байгууллагууд манай улсад нийтдээ 2.6 тэрбум ам.долларын зээл, тусламж үзүүлэхээр тохиролцсоноос манай улс 1.9 тэрбум ам.доллар буюу нийт зээл, тусламжийн 71.9 хувийг нь авч ашиглаад байна.

Зээл, тусламжийн бүтцийг авч үзвэл:

- Зээл-47.6 хувь
- Буцалтгүй тусламж-52.4 хувийг эзлэж байна.

Нийт зээл, тусламжаас:

- Үндсэн төслүүдийг санхүүжүүлэхэд - 38.3 хувь буюу 0.73 тэрбум ам.доллар;
- Төлбөрийн балансад 37.1 хувь буюу 0.7 тэрбум ам.доллар;
- Техник тусламжийн санхүүжилтэд - 24.6 хувь буюу 0.5 тэрбум ам.доллар тус тус зарцуулаад байна.

Өнгөрсөн 10 жилд олгосон зээл, тусламжийн бүтцээс үзэхэд 1991-1994 онд зээл, тусламжийн 70 орчим хувийг төлбөрийн балансыг тэнцвэржүүлэхэд ашиглаж байв.

Харин 1994 оноос улс орны эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахад чиглэсэн дунд болон урт хугацааны төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эзлэх хувийн жин өсч, одоо түүнд 50 гаруй хувийг зориулж байна. Үүнээс:

• Эрчим хүчний салбарт	326.3 сая ам.доллар
• Дэд бүтцийн салбарт	317.1 сая ам.доллар
• Нийгмийн салбарт	268.9 сая ам.доллар
• Үйлдвэрлэлийн салбарт	101.6 сая ам.доллар
• Хөдөө аж ахуйд	86.6 сая ам.доллар
• Байгалийн баялаг, хүрээлэн буй орчны салбарт	20.8 сая ам.доллар
• Бусад салбарт	775.8 сая ам.долларын
зээл тусламж авч ашиглажээ.	

Түли, эрчим хүчний салбарт:

ОХУ-ын 27 орчим сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 1992-1993 онуудад Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын хоёр зуух, хоёр трубиныг шинээр суурилуулах, үнсэн сан болон ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, 3-р цахилгаан станцын вагон хөмрөгч, мазутын аж ахуй, вагон гэсгээгчийн байгууламжийг барих ажлуудыг хийж гүйцэтгэв.

Өнгөрсөн хугацаанд 4-р цахилгаан станцад Япон улсын Засгийн газрын 4.49 тэрбум иен буюу 41.9 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 4 зуухны тоосны системийг үлээлгэнд шилжүүлэх, удирдлагын системийг сайжруулах, зарим хаалт, арматур, халах гадаргууг хэсэгчлэн солих ажлыг хийв.

34 сая ам.долларын буцалтгүй тусламжаар утааны цахилгаан фильтрыг шинэчлэх, тоос дамжуулах төхөөрөмжийн элэгдэл, цооролтыг бууруулах, ажиллагааг сэргээх, үнс зайлуулах системийн ажиллагааг сайжруулах, дулаанжуулалтын тоноглолыг шинэчлэх төсөл зэргийг хэрэгжүүлэв.

3-р дулааны цахилгаан станцад Азийн Хөгжлийн Банкны 40 сая ам.долларын зээлээр 5 зуухны тоосгон системийг шууд үлээлгийн системээр өөрчлөх, хэмжүүр автоматикийн хэрэгслийг шинэчлэх; Нордикийн хөгжлийн сангийн 5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 2

трубины удирдлагын хэмжүүр автоматикийн системийг шинэчлэх ажлуудыг хийв.

АНУ-аас 1992-1996 онд дулааны цахилгаан станцууд ба уурхайнуудын өвлийн ачааллыг давах, доголдол, саатлыг арилгахад зориулан 38 сая ам.долларын буцалтгүй тусламж олгож, түүгээр онц шаардлагатай сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авч нийлүүлэх замаар хэвийн ажиллагааг хангаж байв.

АНУ-ын буцалтгүй тусламжаар 1997 оноос зарим аймгуудын дизель станцыг шинэчлэх, Шарын голын нүүрсний уурхайн тоног төхөөрөмж, машин механизмыг шинэчлэх, эрчим хүчний зарим төхөөрөмжийг шинэчлэх ажлууд хийгдэж байна.

Азийн хөгжлийн Банкны 10 сая ам.долларын зээлээр эрчим хүчний хэмнэлтийн төслийн хүрээнд Улаанбаатар хотын дулааны болон цахилгаан хангамжийн сүлжээг сайжруулах арга хэмжээ хийгдэж байна.

Японы хөнгөлөлттэй зээлээр Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын ТЭЗҮ, Багануурт цахилгаан станц барих ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэв.

Германы хөнгөлөлттэй зээлээр Дарханы цахилгаан станцын 3 зуух, 2 трубиныг шинэчлэх ажлыг хийв.

"ТАСИС" хөтөлбөрийн хүрээнд Чойбалсангийн дулаан цахилгаан станц, Дарханы дулааны шугам сүлжээний ТЭЗҮ-ийг хийв.

Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Даланзадгад хотын дулааны цахилгаан станцын шинэчлэлтийн ажил хийгдэж байна.

Японы 3 сая ам.долларын буцалтгүй тусламжаар нүүрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх "ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах төслийг 1993-1995 онд хэрэгжүүлсэн нь нүүрсний салбарын ойрын ба хэтийн төлвийг тогтоох, хөрөнгө оруулалтын бодлогыг зохицуулах гол үндэс нь болж байна.

Дэлхийн банк, Японы Засгийн газрын тусламжаар Багануур ба Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын ТЭЗҮ-ийг боловсруулав. Үүний дүнд тус улсын хүн ам, үйлдвэрлэл гол төвлөрсөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануур, Чойбалсан хотуудыг түлшээр хангадаг Багануур, Шивээ-Овоо, Шарын гол, Адуунчулууны уурхайнуудад тоног төхөөрөмж, машин механизмын шинэчлэлтүүдийн ажил хийгдэж дуусч байна. Мөн Дэлхийн Банкны 0.7 сая ам.долларын зээлээр Тавантолгойн уурхайн ТЭЗҮ-г боловсруулаад байна.

Зам, Тээврийн салбарт:

Монголын төмөр замд:

ОХУ-аас олгосон 86.8 сая шилжих рублийн зээл нь уг салбарын материал-технологийн баазыг өргөтгөн бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Япон улсын Засгийн газраас төмөр замын тээвэрт зориулж олгосон тусламж, зээлээр Замын-Үүд өртөөний өргөтгөл, шилжүүлэн ачиж, буулгах байгууламж барих, төмөр замын хүч чадлыг бэхжүүлэх арга

хэмжээ авав. Мөн төмөр замын холбооны гол шугамыг шинэчлэх, нефть бүтээгдэхүүн тээвэрлэх цистерний тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авав. Үүний үр дүнд Монгол-Хятадын хил дээр ачаа шилжүүлэн ачих ажиллагааг түргэтгэх, ачааны вагоны хангамжийг сайжруулах нөхцлийг бүрэлдүүлж ашиглалтыг сайжруулах, гадаадаас ачааны вагон түрээслэх явдал багасч улмаар валют хэмнэх нөхцөл бүрдүүлэв.

2001 оноос эхлэн Төмөр замын байгууламжийг сайжруулах төсөлд 869 сая иений буцалтгүй тусламж олгож уг хөрөнгөөр үер усны хамгаалалтыг сайжруулах, уул хадны нуранги тогтоох, гүүр засварлах, зарим газарт төмөр замыг голоос холдуулан шинэчлэн барих, Сүхбаатар хотын ус зайлуулах байгууламжийг сайжруулах зэрэг ажлыг хийх болно. Үүний үр дүнд Сүхбаатар хотоос Замын-Үүд хүртэлх 1100 гаруй км төмөр замын тээврийн найдвартай ажиллагааг хангах урьдчилсан нөхцөл бүрдэх юм байна.

Авто тээврийн салбарт:

Японы зээл, тусламжаар Улаанбаатар хотын автобусны засвар үйлчилгээний станцыг шинээр барьж, Улаанбаатар хотын зорчигч тээвэрт зориулан 100 автобус нийлүүлэгдэв. 26 сая ам.долларын буцалтгүй тусламжаар Налайх-Эрдэнэ сумын хооронд засмал зам тавих ажлыг хийж байна.

Дэлхийн Банкны зээлээр Улаанбаатар хотын зорчигчдын тээвэрт зориулан автобус, троллейбус нийлүүлэх, лабораторыг шинэчлэн тоноглох, компьютер сэлбэг, материал хангамжийг сайжруулах арга хэмжээ авав.

Азийн хөгжлийн Банкнаас уг салбарт олгож байгаа хоёр үе шаттай 50 сая ам.долларын зээлээр Улаанбаатар-Сүхбаатар хотын хоорондох замыг шинэчлэн өргөтгөж, Дархан-Эрдэнэтийн хооронд шинээр бетон гүүр барих ажлыг гүйцэтгэв.

Кувейтын сангаас олгосон 18 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр Дархан-Эрдэнэтийн хооронд шинэ засмал зам тавих ажил хийгдэж байна.

Японы Засгийн газраас Улаанбаатар хотын авто-замыг сайжруулах төслийг хэрэгжүүлэхэд зориулан нэг тэрбум 643 сая иений буцалтгүй тусламж олгоод байна.

Агаарын тээврийн салбарт:

Азийн Хөгжлийн Банкны шугамаар Буянт-Ухаагийн Нисэх онгоцны буудлын өргөтгөл хийгдэж, нисэх хөдөлгөөнийг удирдах тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил дуусч байна.

Холбооны салбарт:

Азийн Хөгжлийн Банк, Герман ба Скандиновын умардын Сангийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, техник тусалцаагаар

Улаанбаатар, Дархан, Эрдэнэтийн телефон хэрэглэгчдийн кабель шугамыг шинэчилж өргөтгөх, Булган, Сүхбаатар, Арвайхээр зэрэг хотуудын радио релейний шугамуудын ажлыг хийж гүйцэтгэв.

Японы буцалтгүй тусламжаар байгуулагдсан Интелсатын газрын станц нь олон улсын чанартай холбоог хөгжүүлэхэд таатай боломж олгосны үр дүнд Монгол Улс дэлхийн 130 гаруй оронтой саадгүй харилцах болов.

Геологи, уул уурхайн салбарт:

Францын Засгийн газрын тусламжаар "Монгол орны геологийн мэдээллийн санг сайжруулах", "Мэдээллийн автоматжуулсан сан бүрдүүлэх" төслүүд хэрэгжүүлж Монгол орны 200000 км² нутаг дэвсгэрийн хэмжээнд сансрын зургийн тоон мэдээлэл бүрдүүлж, орчин үеийн техник технологи нэвтрүүлэв.

Япон улсын тусламжаар "Төвийн хойт хэсэгт геологийн судалгаа явуулах" төслийн хүрээнд 200000 км² талбайд геологийн тогтцыг тодорхойлж, томоохон хүдрийн дүүргүүдийг төлөөлж чадах ордуудаас дээж авч шинжилгээ хийсэн байна. Төслийн хүрээнд программ хангамж, тоног төхөөрөмж нийлүүлжээ.

Канад улсын тусламжаар "Агаарын гео-физикийн зураглалын төв байгууллага" төсөл хэрэгжиж байна.

БНСУ-тай "Монгол орны зүүн хэсэгт сансрын зураг ашиглан геологийн тогтолцооны судалгаа явуулах" төсөл хийгдэж байна.

Дэлхийн Банкны хөрөнгө оруулалттай МОН-97209 төсөл хэрэгжив.

Герман, Чех, Швед, Англи улстай хамтарсан геологи хайгуул, зураглалын төслүүд хэрэгжиж байна.

Барилга-хот байгуулалтын салбарт:

Япон, Дэлхийн Банк, Азийн хөгжлийн байгууллагын техникийн туслалцаа, буцалтгүй тусламжийн хүрээнд нийтийн аж ахуйн салбарт Улаанбаатар хотын 12 гэр хорооллын ус хангамжийг сайжруулах, хог хаягдлыг цэвэрлэх, түүнийг боловсронгуй аргаар тээвэрлэх, цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, Говь-Алтай, Дундговь аймагт гүний худаг гаргах ажлуудын төслийг хэрэгжүүлж байна.

Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарт:

Япон улсын буцалтгүй тусламжаар Дарханы махкомбинат, Улаанбаатарын сүүний үйлдвэрүүдэд өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.

Хөдөө аж ахуйн салбарт:

Азийн хөгжлийн Банк нь газар тариалангийн чиглэлээр тусламж үзүүлж байна.

Дани улс мал аж ахуйн салбарын тоног төхөөрөмж, техник технологийг шинэчлэхэд туслалцаа үзүүлж байна.

Япон улс нь хөдөө аж ахуйн трактор, газар тариалангийн техник, бордоо нийлүүлж байна.

АНУ нь 1997 оноос туслалцаа үзүүлж, улаан буудай нийлүүлж байна.

"ТАСИС" хөтөлбөрийн хүрээнд: Уг хөтөлбөрийг Европын Холбоо 1990 онд санаачлан Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн орнуудад шилжилтийн үеийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжихэд техникийн туслалцааг буцалтгүй тусламж хэлбэрээр үзүүлж байна.

Манай улс 1994 оноос тус Хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллагч улс болсон юм.

Европын Холбооноос Монгол Улсад 1994-1995 онд 8.0 сая евро, 1996-1997 онд 9.5 сая евро, 1998-1999 онд 11.0 сая еврогийн тусламж олгоод байна.

Энэ тусламжийн хүрээнд нийтдээ 70 гаруй том, жижиг төслүүд хэрэгжсэн ба хэрэгжих шатандаа явж байна.

Хандивлагч орнуудаас /хоёр талын үндсэн дээр/ үзүүлж буй зээлийн 20 орчим хувь буюу 207,9 сая ам. долларын зээлийг Япон улс олгосон бөгөөд энэ нь өнгөрсөн жил хандивлагчдаас хоёр талын үндсэн дээр олгосон зээлийн 60 гаруй хувийг эзэлж байна. Үлдсэн 40 орчим хувиас ОХУ /13,6/, Герман /13,2/, Хятад /3,9/, Норвеги /3,5/, үлдэх цөөхөн хувийг бусад орнуудаас олгожээ.

1991-2000 онд Азийн хөгжлийн банкны 0,3 тэрбум, Дэлхийн банкны 0,1 тэрбум ам. долларын зээлийг тус тус авч ашиглажээ. Дээрх зээл тусламжийн ихэнх хэсгийг дэд бүтцийн салбарын үйлдвэрүүдэд зориулсан байна.

Өнөөгийн байдлаар Монгол улсад 67 орны 452 сая гаруй ам. долларын хөрөнгө оруулалт бүхий 1800 гаруй аж ахуйн нэгж байгаагаас зонхилох хэсэг нь худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна. 2000 оны байдлаар эдгээр аж ахуйн нэгжүүд улсын төсөвт 39 тэрбум ам. доллар буюу нийт татварын орлогын 14,2 хувийг эзэлж байлаа. Тооны хувьд хэдий ахиц байгаа ч шинэ техник, технологи нэвтрүүлэх, экспортын нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэгт ямарч ахиц өөрчлөлт гарсангүй. Хамгийн хямд ажиллах хүчин болон манай улсад олгосон худалдааны таатай нөхцлийг ашиглан Хятад, Гонконг, Сингапур, БНСУ-ын бизнесмэнүүд зөөлөн оёдлын үйлдвэрүүд байгуулж гол төлөв АНУ-д гаргаж байлаа. Сүүлийн үед АНУ-д бий болсон нөхцөл байдалтай уялдан ноолууран болон бэлэн хувцасны хэрэглээ эрс буурсан нь энэ төрлийн бизнест таагүй нөлөөлөх хандлагатай болоод байна. Гадаадын хөрөнгө оруулалттай, ялангуяа Хятадын компаниуд Монголын зах зээлд чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлж

чиглэлээр тусламж

төхөөрөмж, техник

риалангийн техник,

н буудай нийлүүлж

йг Европын Холбоо

эмлэгийн орнуудад

члэлтийг дэмжихэд

үүлж байна.

мтран ажиллагч улс

05 онд 8.0 сая евро,

ийн тусламж олгоод

ом, жижиг төслүүд

дээр/ үзүүлж буй

н зээлийг Япон улс

хоёр талын үндсэн

. Үлдсэн 40 орчим

1/3,5/, үлдэх цөөхөн

3 тэрбум, Дэлхийн

н ашиглажээ. Дээрх

арын үйлдвэрүүдэд

452 сая гаруй ам.

йн нэгж байгаагаас

гээний салбарт үйл

аж ахуйн нэгжүүд

арын орлогын 14,2

аа ч шинэ техник,

гдэхүүн үйлдвэрлэх

мд ажиллах хүчин

ийг ашиглан Хятад,

оёдлын үйлдвэрүүд

йн үед АНУ-д бий

н бэлэн хувцасны

лөөлөх хандлагатай

ялангуяа Хятадын

эгдэхүүн нийлүүлж

хялбар аргаар мөнгө олох, Монголын хөдөө аж ахуйн түүхий эд, модны экспортод хяналт тогтоох үндсэн үүрэг гүйцэтгэж байна гэхэд хилсдэхгүй биз ээ. Энд хүн бүхний мэдэх нэгэн баримтыг ч жишээ татаж болох юм. Монгол орны экспортын барааны нэрийн хуудас, валютын орлогын чамгүй хэсгийг эзэлдэг ноолуурын үйлдвэрлэлийн салбарт өнөөдөр 26 үйлдвэр байдаг аж. Түүний 20 гаруй нь Хятадын хөрөнгө оруулалттай, гол төлөв бохироор бэлтгэх үүрэгтэй. Нийт үйлдвэрийн хүчин чадал нь жилд Монгол орноос бэлтгэж болох ноолуурын боломжит хэмжээнээс хэдэн зуу дахин давсан байх жишээтэй. Үүнтэй холбогдуулан дурдахад Хятадын судлаач Х. Фан глобалчлалын өнөөгийн үйл явцад "өрсөлдөөн хийгээд эдийн засагт зонхилох үүрэг гүйцэтгэхийн төлөө тэмцэл, хяналт хийгээд хариу хяналт, хориг хийгээд хариу хориг, хавчлага хийгээд сөрөг хавчлага нь өдгөө олон улсын тэмцлийн үндсэн хэлбэр болон хувирчээ. Энэ утгаар авч үзвэл, өрсөлдөөн өргөжихийн хэрээр "нутаг дэвсгэрт улсууд" "худалдаачин улсуудад" байраа тавьж өгч байна гэж нотолсон байдаг. Үүнийг ч анхаарахад илүүдэхгүй болов уу.

Манайд одоохондоо үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж зах зээлээ уян хатан, зохистой хэмжээнд хамгаалах бодлого үгүйлэгдэж байна. УИХ-ын 2001 оны намрын чуулганаар гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж хөрөнгийнх нь хэмжээг нэмэгдүүлэх зэрэгт анхаарч Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж зарим нааштай хөнгөлөлт үзүүлсэн нь сайшаалтай.

Уул уурхайн олборлох салбарын хувьд уламжлалт ОХУ-ын зэрэгцээ Хятад, АНУ, Канад, Франц, Англи, Болгар, БНСУ нэлээд түлхүү хөрөнгө оруулж эхэллээ. Түүхий эд боловсруулах салбарт Хятад, АНУ, Итали, Англи, Япон зэрэг орнууд идэвхтэй хөрөнгө оруулалт хийж байна. Газрын тосны салбарт нийтдээ 103,7 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийжээ. Саяхнаас Канадын нэг тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт ид яригдаж байна. Барууны орнуудаас энэ мэт стратегийн хөрөнгө оруулагчдыг татах, цаашлаад Зүүн хойт Азийн бүс нутгийн глобалчлал, интеграцчилал, хамтын ажиллагааны хүрээнд Монголын зүүн бүсийн эрдэс баялгийг хоёр болон олон талын төслийн хүрээнд үр ашигтай ашиглах явдал хөгжлийн нэг чухал хүчин зүйл байж болох юм. Зүүн хойд Азийн орнуудад зориулсан банк, мөн хэд хэдэн орнуудыг хамарсан өргөн цар хүрээтэй томоохон санхүүгийн төслүүд сүүлийн үед их яригдах боллоо. Эдгээрт бидний анхаарал сонирхлыг татсан эрчим хүч, нефть, хийн хоолойноос гадна экологи, ундны усны глобал бодлого, түүнчлэн Транс-Азийн төмөр зам, авто зам, мэдээллийн технологийн сүлжээ зэрэг анхаарал татсан төслүүд чих дэлсэж эхэллээ. Манай төр засаг энэ чиглэлд цаг алдалгүй эрэл хайгуул хийвээс ойрын ирээдүйд тодорхой үр дүнд хүрч болох мэт. Үнэхээр ч манай нэгэн улс төрчийн хэлснээр Монголын хөгжил Дорнын талаас өндийн босох цаг тун холгүй гэдэгт итгэлтэй байна.

Гурав. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн хүрэн дэх хамтын ажиллагаа

Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийг баримжаалж эхэлсэн үеэс НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хэмжээ өсч, хүний тогтвортой хөгжил, байгаль орчныг хамгаалах, ядуурлыг бууруулах, удирдлагын үндэсний чадавхийг дээшлүүлэх, гадаадын зээл тусламжийг зохицуулах зэрэг 60 гаруй төсөл өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн, хэрэгжих шатандаа явж байна. Өнгөрсөн хугацаанд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс үзүүлсэн тусламжийн нийт хэмжээ 23,9 сая ам. долларт хүрчээ.

Дөрөв. Гадаад худалдаанд гарсан өөрчлөлт

Гадаад худалдааны бараа эргэлт өнгөрсөн 10 жилд ихээхэн хэлбэлзэлтэй тогтонги бус явж ирлээ.

2000 оны байдлаар гадаад худалдааны нийт эргэлт 1080,6 сая ам. доллар, үүнээс экспорт 466,1 сая, импорт 614,5 ам. доллар болсон байна. 2000 онд гадаад худалдааны тэнцэл 148,4 сая ам. долларын алдагдалтай гарч, 1999 оныхоос 6,1 сая ам. доллараар буурав. 2000 онд экспортолсон зэсийн баяжмалын 94 хувийг Хятадад, 0,6 хувийг ОХУ-д, жоншны баяжмалыг 100 хувь ОХУ-д, молибдений баяжмалыг 100 хувь, ямааны бохир ноолуур, богийн арьс, бодын ширний дийлэнх хэсгийг Хятадад, ямааны самнасан ноолуурын 49,5 хувийг Хятадад, 20,7 хувийг Италид, 15,4 хувийг Англид, 6,7 хувийг Японд, 4,0 хувийг Гонконгод тус тус гаргасан байна. Дээрх үзүүлэлтээс харахад манай орны экспортын барааны бүтцэд чанарын ямар нэг өөрчлөлт гарсангүй. Уламжлалт цөөн нэр төрлийн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнээс бүрдсэн хэвээр байна.

Манай улс дэлхийн 44 оронд бараа экспортлож байгаа бөгөөд нийт экспортын 58,9 хувь нь Хятадад, 19,9 хувь нь АНУ-д, 9,7 хувь нь ОХУ-д, бусад оронд 11,5 хувь тус тус ноогдож байна. Дээрх байдлаас харахад уламжлалт харилцаатай, зам тээврийн хувьд хамгийн таатай хойт хөршид экспортлох бараа бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх асар өргөн боломж, асар их нөөц ашиглагдахгүй байгаа нь харагдаж байна.

Манай улс 61 орноос бараа импортлож байна. Импортонд ОХУ 33,6 хувь, Хятад 20,5 хувь, Япон 12,0 хувь, БНСУ 9,0 хувь, бусад орнууд 25,0 хувийг тус тус эзэлж байна.

Импортын барааны бүтцэд ч чанарын өөрчлөлт гарсангүй. Харин ч хүнс, өргөн хэрэглээний барааны импортын эзлэх хувь эрс өсч байгаа нь харагдана. Энэ нь газар тариалангийн болон үндэсний үйлдвэрлэл хөл дээрээ баттай зогсож чадаагүй байгаатай ямар нэгэн хэмжээгээр холбоотой.

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 1997 онд 4,0, 1998 онд 3,5, 1999 онд 3,2 хувь байснаа 2000 онд 1,1 хувь болж буурчээ. 2000 оны байдлаар нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 400 орчим ам.

доллар байна. Эдийн засгийн хөгжлийн түвшингээрээ дэлхийн 150 гаруй улс орны дараа орж байна.

Азийн Хөгжлийн банкнаас өнгөрсөн 11-р сард гаргасан Ази Номхон Далайн Бүс нутгийн эдийн засгийн байдлыг урьдчилан таамагласан судалгааны мэдээнээс үзэхэд террористуудын халдлага болон бусад хүчин зүйлтэй уялдан 2002 онд Азербайжан, Монгол зэрэг оронд эдийн засгийн өсөлт буурах магадлалтай байгаа аж. Түүнчлэн хоёр жил дараалан болсон байгалийн гамшиг, малын шүлхий зэрэг нь Монголын экспортын хэмжээг мөн нэгэн адил нэлээд бууруулна гэсэн баргардуу дүгнэлт ч гаргажээ. Нөгөө талаар зэс, ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ унасан хэвээр байгаа зэрэг зохисгүй хүчин зүйлс ч энд нөлөөлөх нь мэдээж. Өөр бусад янз бүрийн хүчин зүйл, гэнэтийн болзошгүй хямрал бэрхшээлийг аль болох цаг алдалгүй урьдчилан харж бүсийн болон олон улсын эдийн засгийн байгууллагуудтай уялдуулан зохицуулсан бодлого баримтлах асуудал өнөөдөр буурай хөгжилтэй, хараат эдийн засагтай Монгол шиг жижиг оронд хэзээ хэзээнээс илүү чухлаар тавигдаж байна.

Саяхан Хятад улс ДХБ-д гишүүнээр элслээ. Түүнд нь Монгол улс ч дэмжлэг үзүүлсэн. Хятад улс зах зээлээ дэлхийд нээж, гаалийн татвараа бууруулах үүргийг ДХБ-ын өмнө хүлээсэн. Бид энэ тал дээр шуурхай ажиллах хэрэгтэй болов уу. Худалдаа, эдийн засгийн энэхүү таатай нөхцлийг ашиглан бүс нутгийн интеграцийн хүрээнд манай бизнесмэнүүд Хятадад хөрөнгө оруулалт хийж хүч сорих боломж нээгдлээ.

Өнгөрсөн 10 жилийн эдийн засгийн гадаад харилцаанд баримталж ирсэн бодлогыг ажиглахад Засгийн газрууд өмнөх Засгийн газруудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг үгүйсгэсэн, түр зуурын бодлогын шинж чанартай эдийн засгийн богино хугацааны зорилтуудад ихэвчлэн анхаарч гадаадын зээл тусламжийн хөрөнгийг хэт олон чиглэлд ашигласан нь үр ашиг багатай, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлжээ.

Иймд гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын зээл тусламжийн чиглэлийг оновчтой сонгон, ашиглалт үр өгөөжийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулахад чиглэсэн тодорхой бодлого, хэтийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хариуцлага, гүйцэтгэлийн хяналтыг хүчтэй болгохгүй бол Азийн Африк болоход тун ойрхон байна. Өнгөрсөн 10 жилд эдийн засгийн гадаад харилцааны байгууллагын бүтцийг олон янзаар өөрчилсөөр ирлээ. 2000 оны Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр дахин шинэчлэгдэж эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлыг 6 яам субъектэд тарааж тарамдуулжээ. Энэ яавч эрүүл саруул бодлого биш байх. Бидэнд үндэсний хэмжээнд зөвшилцсөн, аль ч засгийн газрын үед хувирч өөрчлөгддөггүй барьж, мөрдөж байх урт хугацааны хөгжлийн бодлого үгүйлэгдэж байна. Манайх шиг буурай хөгжилтэй, хараат эдийн засагтай, жижиг орны хувьд улсын хэмжээнд хөгжлийн асуудлаар судалгаа хийж бодлого боловсруулдаг, төрийн ивээл дор ажилладаг бие даасан хараат бус байгууллага ч байгуулж болох мэт санагдана.

Монгол улсын хөгжил дэвшилд тэргүүлэх ач холбогдолтой зүйл бол хүн билээ. Иймд бид өөрсдийгээ эхлээд сайн судлах хэрэгтэй болжээ.

Одоохондоо манайд хүнд хөрөнгө оруулахаасаа малдаа түлхүү хөрөнгө оруулалт хийгээд байна. Монголын нэг малд жилд дундаар 1-2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж байгаа гэсэн бүрэн бус судалгаа бий. Энд мэдээж гадаад дотоод бүх төрлийн тусламж, хандив орсон. Гэтэл мал нь үрэгдээд хүн нь ядуураад байдаг.

Боловсролын өнөөгийн тогтолцоог улам боловсронгуй болгож олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн боловсрол олгох цаг нэгэнт болжээ. Малд бус залуу үед оруулах хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үнэхээр хөдөлмөрлөж, хуримтлал бий болгож чадсан, менежмент сайтай, нийтээр хүлээн зөвшөөрсөн үндэсний хөрөнгөтнүүдийг төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлж эх орныхоо өмнө үүрэг хүлээлгэж, итгэл үзүүлэх цаг болжээ. Түүнчлэн элэг нэгтэн цагаачдыг Монголын хөгжилд ашиглах асуудлыг ч бодлогын хэмжээнд авч үзүүштэй санагдана.

Яагаад улс орондоо залхуу гэгддэг залуус гадагш гарахаараа өдөр шөнөгүй гүрийж чадаж байна. Энэ хөшүүргийг Монголд яаж бий болгох вэ? Манайд чадварлаг менежент аль шатанд асар их үгүйлэгдэж байна. Хүний хөгжил, менежментийн асуудалд анхаарахгүй бол Монгол улс сүүдрийн эдийн засаг, коррупци хоёрт идэгдэж дуусах нь. Ард олныг өнөөгийн хэрэглээгээ хязгаарлан ирээдүй хойч үе, улс орныхоо тусын тулд анхны хуримтлал бий болох сэтгэлгээг бий болгохгүйгээр урагш хөгжинө гэвэл бас л эргэлзээтэй. Манайд өнөөдрийн олсноо өдөрт нь хэрэглэж дуусгах сэтгэлгээ ноёрхсон хэвээр байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын хүнд суртал газар авч байгаа нь урагшлах хөдөлгөөнд бас нэг бул хар чулуу боллоо. Тэдэнд хариуцлага хүлээнэ гэдэг ойлголт байхгүй болжээ. Улс орон, байгууллагын эрх ашигт ноцтой хохирол учруулсан албан тушаалтныг сайндаа л ажлаас нь чөлөөлж байх жишээтэй.

Эдийн засгийн глобалчлалын өнөөгийн нөхцөлд олон улсын эдийн засгийн байгууллага болон улс орнуудтай үйл ажиллагаагаа хэрхэн шуурхай уялдуулан зохицуулах вэ? НҮБ болон олон улсын банк, санхүүгийн байгууллага Монголд суурин Төлөөлөгчийн газраа нэгэнт байгуулж Засгийн газарт удирдамж чиглэл өгч эхэллээ. Энэ нь нэг ёсны мини засгийн газрын үүрэг гүйцэтгэж байна гэсэн үг. Манай засгийн газар тун удахгүй хүссэн хүсээгүй менежерийн үүрэг гүйцэтгэх болно. Сайн менежер улс гэрээ авч явна. Саар нь элдэв бэрхшээл зовлон тоочин өгсөн хэдийг нь үр ашиггүй үрэлгэн зарцуулснаар уршиг нь улс орон, ард түмний нуруун дээр буух болно.

Эдийн засгийн гадаад харилцааг Монгол улсын хөгжлийн стратегитэй уялдуулах үүднээс дараахи чиглэлд анхаарах нь зүйтэй болов уу.

- Гадаад орнуудтай хөдөлмөрийн захын харилцааг өргөжүүлэх;
- Хүн амын нягтрал суурьшлын асуудалд гадаадын зээл тусламжийн тодорхой хэсгийг ашиглах;
- Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлдэг салбарууд болох аж үйлдвэр, хөдөө аж ахуй, барилгын

салбарт тэргүүлэх ач холбогдол өгч түлхүү хөрөнгө оруулалт хийх, гадаадын хөрөнгө оруулагчдыг энэ чиг хандуулах;

- Хот, хөдөөг холбосон жижиглэнгийн бөөний худалдааны сүлжээ байгуулах;
- Бэлчээрийн мал аж ахуй нэгэнт хуучнаараа цааш явах боломжгүй болсон тул эрчимжсэн мал аж ахуй буюу фермерийн хэлбэрт шилжүүлэх;
- Махны экспортыг түлхүү анхаарах;
- Оюунлаг үйлдвэрлэлийн төрөл болох компьютер, мэдээллийн технологийн чиглэлээр Монголд зүүн хойт Азийн бүсийн угсрах сүлжээг бий болгох асуудал юм.

Цэвэр экспортыг нэмэгдүүлэх үүднээс уламжлалт зэс, молибден, жонш, алт, уран, газрын ховор элемент, цайр, тугалга зэргийг боловсруулан экспортлох, энэ чиглэлд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, мал аж ахуйн бүтээгдэхүүнд гүн боловсруулалт хийж, дэлхийн стандартад хүрсэн, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх; аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд дотоод гадаадын эх үүсвэрийг түлхүү ашиглах, тэргүүлэх ач холбогдол өгөх зэрэг болно.

This article attaches the highest priority to dynamic changes that occurred in foreign trade and economy for the last 10 years due to the country switching to market oriented economy and thanks to pursuing open foreign policy, and geographical changes of the foreign trade. Author focuses also on principles of foreign economic relations of Mongolia, by especially highlighting such areas of it like investment, foreign aid and loans as well as infrastructure.

Ашигласан материал:

1. Монголын гадаад худалдааны "Цагаан ном" УБ., 2001
2. Д. Галсандорж, Х.Буд 'Монгол Улсын Эдийн Засгийн Гадаад Харилцааны Товч Түүх' /1921-2000/ УБ., 2001
3. Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2000 УБ., 2001
4. Гадаад Бодлогын Хөх Ном УБ., 2000
5. Монголын хөгжлийн стратеги /онол практикийн хандлагууд/ УБ., 1999